



ДАРХАН-УУЛ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 01-А/195

Дархан

Санхүүжилт олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.7 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 54 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Дархан-Уул аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалт”-ын 1.4.2 “Иргэдийн оролцоотой төсөл хөтөлбөр”-өөс санхүүжих Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Нийгмийн даатгалын газар, Онцгой байдлын газар, Соёл, урлагийн газар, Стандарт, хэмжил зүйн хэлтэс, Татварын газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Ахмадын хөгжлийн төв ОНӨААТҮГ, Дархан хотын соёл, амралтын хүрээлэн ОНӨААТҮГ, Дархан-Уул аймгийн 7 дугаар цэцэрлэг, аймгийн Засаг даргын Тамгын газар (ХБТХОХ), Хүнс, хөдөө аж ахуйн газруудад хэрэгжих төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах 140,000,000 (нэг зуун дөчин сая) төгрөгийг төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтаар батлагдсан төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах, гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангах, тайлагнах эрхийг төсвийн шууд захирагч нарт олгосугай.

3. Батлагдсан төсөл, арга хэмжээг холбогдох хууль журмын дагуу санхүүжүүлэхийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (П.Батсүх)-д, Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Жаргалсайхан)-т тус тус зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тайлагнахыг Засаг даргын орлогч (Б.Жавхлан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АЗЖАРГАЛ



4524010652

Аймгийн Засаг даргын 2024 оны 04.
дүгээр сарын 21-ны өдрийн 027/195
дугаар захирамжийн хавсралт

“ИРГЭДИЙН ОРОЛЦООТОЙ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР”-ӨӨС
САНХҮҮЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

(мянган төгрөг)

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2024 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
1	Дизайн сэтгэлгээ төсөл /Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар/	2024	2024	10,000.0	10,000.0
2	Ухаалаг самбар төсөл /Нийгмийн даатгалын газар/	2024	2024	20,000.0	20,000.0
3	Гадна хаяг шинэчлэх төсөл /Онцгой байдлын газар/	2024	2024	10,000.0	10,000.0
4	Уран зургаар чимэглэсэн 8 ханатай халх гэр төсөл /Соёл, урлагийн газар/	2024	2024	10,000.0	10,000.0
5	Засвар, камержуулах төсөл /Стандарт, хэмжил зүйн хэлтэс/	2024	2024	10,000.0	10,000.0
6	Эрүүл аюулгүй ажлын байр төсөл /Татварын газар/	2024	2024	10,000.0	10,000.0
7	Иргэн төвтэй төрийн үйлчилгээ төсөл /Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэс/	2024	2024	10,000.0	10,000.0
8	Тоног төхөөрөмж төсөл /Эрүүл мэндийн даатгалын хэлтэс/	2024	2024	10,000.0	10,000.0
9	Насны хөгжихүйн орчин төсөл /Ахмадын хөгжлийн төв ОНӨААТҮГ/	2024	2024	10,000.0	10,000.0
10	Тоглоомын орчныг сайжруулах төсөл /Дархан хотын соёл, амралтын хүрээлэн ОНӨААТҮГ/	2024	2024	10,000.0	10,000.0
11	Монгол ёс уламжлалын өргөө төсөл /Дархан-Уул аймгийн 7 дугаар цэцэрлэгт/	2024	2024	10,000.0	10,000.0
12	Тохижилт, тоног төхөөрөмж төсөл /Хүнс, хөдөө аж ахуйн газар/	2024	2024	10,000.0	10,000.0
13	Ухаалаг ажлын байр төсөл /Аймгийн Засаг даргын Тамгын газар, ХБТХОХ/	2024	2024	10,000.0	10,000.0
	Нийт дүн			140,000.0	140,000.0